

ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ, ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНИЙ
ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ОЛГОХ ЖУРАМ

2024.06.27

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь иргэн, хуулийн этгээдийн цахилгаан тоног төхөөрөмж, шугам, дэд станцыг цахилгаан дамжуулах, түгээх сүлжээнд холбуулах хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх, зөвшөөрөл олгох, сүлжээнд холбож, хүчдэлд залгах үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг хариуцлага, эрх хэмжээг тодорхойлоход оршино.

1.2. "ДБЭХС" ТӨХК-ийн дамжуулах, түгээх сүлжээнд иргэн, хуулийн этгээдийн цахилгаан тоног төхөөрөмж, шугам, дэд станцыг холбоход энэхүү журмыг мөрдөнө.

1.3. Иргэн, хуулийн этгээдийн цахилгаан тоног төхөөрөмж, шугам, дэд станцыг цахилгаан дамжуулах, түгээх сүлжээнд холбох эрх бүхий байгууллагын шийдвэр нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн олгосон техникийн нөхцөл байна.

1.4. Тусгай зөвшөөрлийг олгоход Эрчим хүчний тухай хууль, Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм, Тусгай зөвшөөрөл эзэмшигч болон хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм, Цахилгаан дамжуулах түгээх сүлжээний холболтын журмыг үндэс болгоно.

ХОЁР. Сүлжээнд холбогдох хүсэлт гаргах, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх

2.1. Цахилгаан дамжуулах, түгээх сүлжээнд шинээр холбогдох, техникийн нөхцөлд заасан чадлыг нэмэгдүүлэх, бууруулах, сүлжээний техникийн шийдлийг өөрчлөх тухай бүрд техникийн нөхцөл авна.

2.2. Иргэн, хуулийн этгээд нь цахилгаан дамжуулах, түгээх сүлжээнд холбогдох тухайн байршил дээр цахилгаан чадал нэмж холбох боломжтой эсэх лавлагааг сүлжээний нөөцийн мэдээллээс авах боломжийг тусгай зөвшөөрөл эзэмшигч нь бүрдүүлсэн байна.

2.3. Цахилгаан дамжуулах, түгээх сүлжээнд холбогдохоор хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээд нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн харъяа хүсэлт хүлээн авах цэгүүдэд өөрийн биеэр ирж болон e-mongolia цахим систем ашиглан энэхүү журамд заасан материалыг бүрдүүлэн хүсэлт гаргана.

2.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь иргэн, хуулийн этгээдийн баримт бичгийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор судалгааг хийж иргэн, хуулийн этгээдэд техникийн нөхцөл олгох боломжтой эсэх хариуг мэдэгдэнэ.

2.5. Цахилгаан түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Сүхбаатар аймгийн иргэн, хуулийн этгээдэд техникийн нөхцөл олгохдоо цахилгаан дамжуулах сүлжээний горим ажиллагааны хэвийн нөхцлийг хангуулах зорилгоор дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн саналыг үндэслэн техникийн нөхцөл олгоно.

2.6. Техникийн нөхцлийн саналыг хүлээн зөвшөөрч хариу өгсөн иргэн, хуулийн этгээдийн техникийн нөхцлийг ажлын 5 хоногт багтаан гаргана.

2.7. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь техникийн нөхцөл олгохдоо хэрэглэх чадлын хэмжээ, дамжуулах, түгээх сүлжээний ачаалал, тухайн бүс нутгийн өсөн нэмэгдэх цахилгааны хэрэглээ, хэтийн төлөвтэй уялдуулан шийднэ.

2.8. Техникийн нөхцлийг олгохдоо барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, шинэчлэх талаар эрх бүхий байгууллагын шийдвэр, тусгай зөвшөөрөл эзэмшигчид гаргасан хүсэлт, газар олголтын захирамжийг үндэслэнэ.

2.9. Иргэн, хуулийн этгээд нь техникийн нөхцөл авахад шаардлагатай дараах баримт бичгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид бүрдүүлж өгнө.

2.9.1. Өргөдөл буюу албан хүсэлт;

2.9.2. Иргэний үнэмлэхний хуулбар(эх хувь);

2.9.3. Хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар (эх хувь эсвэл хуулбар хувийг нотариатаар гэрчлүүлсэн байх);

2.9.4. Газрын гэрчилгээ (Өмчлөх, ашиглах, эзэмших), (эх хувь эсвэл хуулбар хувийг нотариатаар гэрчлүүлсэн байх);

2.9.5. Газрын кадастрын зураг(эх хувь эсвэл хуулбар хувийг нотариатаар гэрчлүүлсэн байх);

2.9.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн баталсан маягтын дагуу тодруулах хуудас бөглөх;

2.10. Иргэн, хуулийн этгээд нь энэхүү журмын 2.9 дүгээр зүйлд заасан баримт бичгээс гадна хүсэлтийн онцлогоос хамаарч дараах материалуудыг бүрдүүлсэн байх шаардлагатай. Үүнд:

2.10.1. Хот, тосгоны ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөтэй уялдуулан барилга орон сууц барих тохиолдолд Архитектур төлөвлөлтийн даалгавар, батлагдсан "Ерөнхий төлөвлөгөө" (эх хувь эсвэл хуулбар хувийг нотариатаар гэрчлүүлсэн байх);

2.10.2. Олгогдсон техникийн нөхцөлд өөрчлөлт оруулахад тухайн техникийн нөхцөлийн хуулбар хувь;

2.10.3. Техникийн нөхцлийн нэр шилжүүлэхэд олгогдсон техникийн нөхцөл, газрын гэрчилгээ, харъяа хорооны тодорхойлолт;

2.10.4. Цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний байршлыг өөрчлөхөд тусгай зөвшөөрөл эзэмшигчээс зураг төсөлд тодруулга хийсэн тодорхойлолт, харъяа орон нутгийн ерөнхий төлөвлөгөө эрхэлсэн газрын албан бичиг;

2.10.5. Техникийн нөхцлийн төсөл нь хувийн эзэмшлийн шугам сүлжээнээс холбогдохоор шийдвэрлэгдсэн тохиолдолд шугам сүлжээ эзэмшигчээс заавал бичгээр зөвшөөрөл авсан байх шаардлагатай.

2.10.6. Техникийн нөхцөл гаргуулсан хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн шугам сүлжээг ашиг олох зорилгоор ашиглахыг хориглоно.

2.11. Дараахь тохиолдолд иргэн, хуулийн этгээдийн техникийн нөхцөл хүссэн хүсэлтийг ажлын хэсгээр хэлэлцүүлэхгүйгээр 7 хоногийн дотор буцаана:

- Газрын маргаантай, газрын эрхийн гэрчилгээ, баталгаажсан кадастрын зураг, хүсэлт, бусад баримт бичгийн эзэмшигчийн нэр зөрүүтэй;
- Шаардсан бичиг баримтын бүрдэл дутуу.

- Эрчим хүчний шугам сүлжээний хамгаалалтын зурвас зөрчсөн.

2.12.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь цахилгааны өндөр хэрэглээ, ачаалал бүхий орон сууцны хороолол, томоохон цогцолбор байгууламжид техникийн нөхцөл олгохдоо тэдгээрийн барилга угсралтын үеийн цахилгааны хэрэглээг түр хангах техникийн нөхцлийг салган олгож болно.

2.13.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь техникийн нөхцөлийг 2 жилийн хугацаатай олгоно.

2.14.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нэгдсэн техникийн нөхцөлтэй хэд хэдэн иргэн, хуулийн этгээдийн техникийн нөхцлийг аж ахуй нэгжийн гэрчилгээ, үл хөдлөх хөрөнгийн болон газрын гэрчилгээ, цахилгаан эрчим хүчээр хангах гэрээг үндэслэн техникийн хувьд боломжтой нөхцөлд тус тусад нь олгож болно.

2.15.Сүлжээ төлөвлөлт, горимын онцгой ач холбогдол бүхий нийтийн сүлжээ, магистраль шугам үүсгэхээр хэсэгт иргэн, хуулийн этгээд өөрийн хөрөнгөөр дэд станц, шугам тоноглол барихаар зайлшгүй шаардлага гарч техникийн нөхцөл олгох тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчид тухайн дэд станц, шугам, тоноглолыг шилжүүлэх талаар техникийн нөхцөлд тодорхой зааж тусгана.

2.16.Иргэн, хуулийн этгээдийн барилга байгууламжийг сүлжээнд холбоход бусад хэрэглэгчийн өмчлөлийн шугам, дэд өртөө, хуваарилах байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглах бол тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн хэрэглэгчтэй урьдчилан тохиролцоно.

2.17.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь иргэн, хуулийн этгээдийн холболтын хүсэлтийг шийдвэрлэсэн хугацаа, үндэслэл зэргийг өөрийн цахим хуудсанд сар бүр нийтэлнэ.

2.18.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь техникийн нөхцөл олголтын талаарх мэдээг улирал тутам Эрчим хүчний зохицуулах хороонд хүргүүлнэ.

2.19.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олгосон техникийн нөхцлийн судалгаанд үндэслэн дамжуулах, түгээх сүлжээнд нэмэгдэх болон хүлээгдэж буй чадлыг тооцон гаргаж сүлжээ төлөвлөлтөнд ашиглана.

2.20.Техникийн нөхцөл олгох ажлын хэсэг нь доорх бүрэлдэхүүнтэй байна.

Үндсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

- | | |
|------------------------|--|
| 1. Ажлын хэсгийн дарга | Ерөнхий инженер |
| 2. Гишүүн | ЭХБХ-ийн техник үйлчилгээний инженер |
| 3. Гишүүн | ХААХ-ийн ХАБ инженер |
| 4. Гишүүн | ХХ Хуулийн мэргэжилтэн |
| 5. Гишүүн | Цахилгаан шугам сүлжээний цехийн дарга |

Дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүн

- | | |
|------------------|------------------------------|
| 1. Хэсгийн дарга | Сүхбаатар ЦТСС-ын дарга |
| 2. Гишүүн | Сүхбаатар ЦТСС ахлах инженер |
| 3. Гишүүн | Сүхбаатар ЦТСС ХХААБ инженер |

2.21.Үндсэн ажлын хэсэг нь Дорнод аймгийн нутаг дэвсгэр дэх 0,22кВ-35кВ хүчдлийн цахилгаан түгээх сүлжээнд холбогдох хүсэлт гаргасан иргэн, аж ауйн нэгж, Сүхбаатар аймгийн 35кВ-ын цахилгаан түгээх сүлжээнд холбогдох хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгжүүдэд техникийн нөхцөл олгох асуудлыг хариуцна.

2.22.Дэд ажлын хэсэг нь Сүхбаатар аймгийн 0,22- 15кВ хүртэл цахилгаан түгээхсүлжээний холболтын техникийн нөхцлийг хариуцна.

2.23. Иргэн, хуулийн этгээдийн техникийн нөхцөл хүссэн өргөдөл, албан бичгийг ЭХБХ-ийн хэрэглэгчид хүлээн авах төвд хүлээн авах ба шаардлагатай албан бичгүүдийг захирлын туслах шууд хүлээн авч болно.

2.24. Ирсэн хүсэлтүүдийг захирлын туслах гүйцэтгэх захиралд танилцуулсны дараа ХХАТ-ийн ахлагчид даруй дамжуулан өгнө. Албан бичгийн бүртгэлийг ХХАТ хийх ба ЦШС-ний цехийн дарга, ашиглалтын инженер, мастерт хүлээлгэн өгнө. Холбогдох ажлын хэсгийн шийдвэрийг гүйцэтгэх захирал баталгаажуулна.

2.25. 1кВ-оос дээш хүчдэлийн болон 1кВ хүртэл хүчдэлийн 250кВа-аас дээш хүчин чадал бүхий хэрэглэгч бүрийг шийдвэрлэх асуудлыг комиссын гишүүдийн хурлаар сар бүрийн 2 болон 4 дэх 7 хоногийн баасан гарагийн 14.00 цагт ажлын хэсгийн даргын өрөөнд хуралдаж шийдвэрлэх ба ЦШС-ний цехийн дарга хуралдаанд орох асуудлыг бэлтгэж танилцуулна.

2.26. Техникийн нөхцөлийг үндэслэл муутай олгосноос учирсан хохирлыг энэ дүрмийн 1.3-т заасан уг техникийн нөхцлийг олгосон этгээд хариуцна.

ГУРАВ. Санхүүгийн нөхцөл

3.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь иргэн, хуулийн этгээдийн дэд станц, шугам, тоноглолыг дамжуулах, түгээх сүлжээнд холбоход хүсэлт судлах, техникийн нөхцөл олгох, техникийн нөхцлийн дагуу холбох үйлчилгээ үзүүлэх төлбөрийг иргэн, хуулийн этгээдээс авна.

3.2. Айл өрхийн ахуйн хэрэглээнд 10кВт хүртэл чадалтай 220В-ын хүчдэлд холбогдох хүсэлт гаргах тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь газрын гэрчилгээг үндэслэн техникийн нөхцөл олгох төлбөр төлүүлэхгүйгээр холбох зөвшөөрөл олгоно. Бусад тохиолдолд доорх байдлаар үйлчилгээний хураамж төлнө.

- 380В-ын сүлжээнд холбогдох бол 100000төгрөг
- 6-15кВ-ын сүлжээнд холбогдох бол 200000төгрөг
- 35кВ-ын сүлжээнд холбогдох бол 400000төгрөг

ДӨРӨВ. Техникийн нөхцөлийн агуулга

4.1. Техникийн нөхцөлд дараах асуудлыг тусгасан байна.

4.1.1. Цахилгааны тооцоот дээд ачаалал

4.1.2. Холболт хийх цэг (дамжуулах, түгээх шугам, дэд станц, тоноглол), таслах, залгах тоноглолын марк,

4.1.3. Холболтын схем,

4.1.4. Объектыг шинээр холбосноос болон хэрэглэгч хэрэглээг нэмэгдүүлсэнтэй холбогдуулан өргөтгөл хийх эсэх,

4.1.5. Тоолуур, хэмжих хэрэгсэл.

4.1.6. Объектод тавигдах тусгай шаардлага.

4.1.7. Объектын ашиглалт, аюулгүй ажиллагааг хангах шаардлага.

4.1.8. Иргэн, хуулийн этгээд нь объектыг барих явцад цахилгаан авах шаардлага гарвал түр холболт хийх цэг, хугацааг тодотгосон байх.

4.1.9. Орчны тохижилтыг нөхөн сэргээх талаар авах арга хэмжээ.

4.1.10. Техникийн нөхцөлийн хугацаа.

4.1.11.Холбогдох тогтоол шийдвэрийн заалт.

4.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь иргэн, хуулийн этгээдийн гаргасан хүсэлтийн дагуу зориулалт, чадал, холболтын цэг, тухайн холбогдож буй сүлжээний онцлогоос хамааруулан техникийн нөхцлийн тусгай заалтууд хэсэгт нэмэлт шаардлагуудыг оруулна.

ТАВ. Объектыг сүлжээнд холбох

5.1.Техникийн нөхцөлд тусгасан шаардлагыг бүрэн хангасан дэд станц, шугам тоноглолыг цахилгаан дамжуулах, түгээх сүлжээнд холбоно.

5.2.Цахилгаан дамжуулах, түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн сүлжээний тоноглолыг өөрчлөх, өргөтгөх, газардуулгын байгууламжийн хэмжилт, кабель шугамын туршилт, реле хамгаалалтын тавилын тооцоо хийж тавил тавих, өөрийн дэд станц, шугам тоноглолыг хүчдэлд залгах ажлыг "ДБЭХС"ТӨХК-аар гүйцэтгүүлнэ.

5.3.Иргэн, хуулийн этгээд нь батлагдсан техникийн нөхцлийн дагуу өөрийн шинээр барих дэд станц, шугам тоноглолын зураг төсөв, угсралт, хэмжилт туршилтын ажлыг (хүчний кабелийн туршилт, газардуулгын эсэргүүцэл хэмжих, тооцооны тоолуур шалгахаас бусад г.м) бусад эрчим хүчний барилга байгууламж барих эрх бүхий тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагаар гүйцэтгүүлж болно.

5.4.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь иргэн, хуулийн этгээдэд олгосон техникийн нөхцөлийн дагуу захиалсан чадлын нөөц, техникийн боломжийг тухайн дэд станц, шугам, тоноглолд хадгална.

5.5.Иргэн, хуулийн этгээд нь дэд станц, шугам тоноглолыг сүлжээнд холбоход бүрдүүлсэн гүйцэтгэлийн баримт бичгийг архив, мэдээллийн санд бүртгүүлэн, хүчдэлд залгаж болох тухай ашиглалтанд оруулах комисс ажиллуулж дүгнэлт гаргуулсан байна.

5.6.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь иргэн, хуулийн этгээдийн саналыг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор ашиглалтанд оруулах комиссын дүгнэлтийг үндэслэн шуурхай ажиллагааны нэр, дугаар олгож иргэн, хуулийн этгээдтэй цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ байгуулан мэдээллийн санд бүртгэж, сүлжээнд залгах зөвшөөрөл олгоно.

5.7.Иргэн, хуулийн этгээд нь олгосон техникийн нөхцлийн дагуу мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн зураг төслийг барилга-угсралтын ажил эхлэхээс өмнө уг зураг төслийн зохиогчтой хамтран холбогдох тусгай зөвшөөрөл эзэмшигч /дамжуулагч, түгээгч/-ээр хянуулж баталгаажуулсан байна.

5.8.Техникийн нөхцөл олгосон өдрөөс хойш тухайн шугам сүлжээнд өөрчлөлт /хүчин чадлыг ихэсгэх, багасгах, хэтийн төлөвийн схемээр өөрчлөгдөх, татан буугдах гэх мэт/ орвол тусгай зөвшөөрөл эзэмшигч нь захиалагч /иргэн, хуулийн этгээд/ буюу зураг төслийн байгууллагад мэдэгдэж техникийн нөхцлийг тодотгож байх үүрэгтэй.

5.9.Техникийн нөхцлийн шаардлагын биелэлтийг тухайн дэд станц, шугам тоноглолыг ашиглалтад хүлээн авах үед шалгаж, зураг төслийн байгууллагатай тохиролцолгүйгээр өөрчлөлт оруулсан тохиолдолд зураг төсөл буюу угсралтад техникийн нөхцлийн дагуу зохих өөрчлөлт хийлгэнэ.

5.10.Захиалагч (иргэн, хуулийн этгээд)-ийн шинээр барьсан буюу шинэчилж өөрчилсөн цахилгаан тоног төхөөрөмж нь цахилгаан тоног төхөөрөмжийн угсралтын болон барилгын норм, дүрэм, өгөгдсөн техникийн нөхцөлийн шаардлагыг бүрэн хангасан байвал зохино.

5.11.Шинээр дэд станц, шугам тоноглол холбуулж буй иргэн, хуулийн этгээд нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өмчлөлд байгаа дэд станц, шугам тоноглолыг өргөтгөсөн бол өргөтгөсөн дэд станц, шугам тоноглол нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өмчлөлд байна.

5.12.Иргэн өөрийн эзэмшлийн шугам, тоног төхөөрөмжид хэрэглэгч холбуулахдаа түгээх сүлжээний найдвартай тасралтгүй ажиллагаатай холбоотой эрх бүхий байгууллагаас тавих шаардлагыг биелүүлнэ.

5.13.Өөрийн эзэмшлийн шугам сүлжээг хариуцах мэргэжлийн нэгж хэсэггүй хэрэглэгч нь хангагч байгууллагатай "Шуурхай үйлчилгээний гэрээ" байгуулна.

5.14.Шинээр холбогдох шугам сүлжээний материалууд нь "ДБЭХС"ТӨХК-ийн техникийн шаардлагыг хангасан байна.

ЗУРГАА. Техникийн нөхцөл олгохгүй байх, хүчингүй болгох тохиолдол

6.1.Техникийн нөхцлийг дараах үндэслэлээр олгохгүй. Үүнд:

6.1.1.Газрын маргаантай болон газрын гэрчилгээ, баталгаажсан кадастрын зураг, хүсэлт, бусад бичиг баримтын эзэмшигчийн нэр зөрсөн байх,

6.1.2.Техникийн нөхцөл авахад энэхүү журмын 2.8 дахь заалтанд заасан бүрдүүлэх үндсэн материал дутуу бол хүсэлтийг хүлээн авах боломжгүй, мөн 2.9 дахь заалтын дагуу хүсэлтийн онцлогоос хамааруулан нэмэлт бичиг баримт, материалыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид бүрдүүлж өгөөгүй тохиолдолд,

6.1.3.Иргэн, хуулийн этгээдийн барилга байгууламжийг сүлжээнд холбоход тоноглолын нөөц хүрэлцэхгүй байх, шинээр барих, зөөх дэд станц, шугамын трасс нь нийслэл, орон нутгийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөтэй уялдахгүй, тухайн орчинд нийтийн сүлжээ үүсэх боломжийг хаах тохиолдолд,

6.1.4.Цахилгаан түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн эзэмшлийн түгээх сүлжээнд иргэн, хуулийн этгээдэд техникийн нөхцөл олгохдоо дамжуулах сүлжээнд холбогдох техникийн нөхцөлд заагдсан хүчин чадлаас хэтрүүлсэн тохиолдолд,

6.1.5.Цахилгаан эрчим хүчний найдваржилтын 1-р зэргийн хэрэглэгчийн эрчим хүчний тасралтгүй ажиллагааг хангахад хүндрэл учруулж болзошгүй тохиолдолд

6.1.6.Эрчим хүчний хуулийн 33 дугаар зүйлд заасан болон Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэмийн дагуу цахилгаан болон дулааны шугам сүлжээний зөрчилтэй бол

6.2.Техникийн нөхцөлийг дараах үндэслэлээр хүчингүй болгоно.

Үүнд:

6.2.1.Техникийн нөхцөл авахын тулд техникийн хэрэглээний өгөгдлүүдээ буруу тодорхойлсон,

6.2.2.Холболт хийх цэгийн хүчин чадлаас хэтрүүлэн техникийн нөхцөл олгосон,

6.2.3.Техникийн нөхцөл хүчинтэй байх хугацаанд сүлжээнд холбогдоогүй.

ХЯНАСАН:

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

Ө.ЖАРГАЛСАЙХАН

ХААХ-ИЙН ДАРГА

Н.БААСАНПҮРЭВ

СҮХБААТАР ЦТСС-ЫН ДАРГА

Р.ЭРДЭНЭЦОГТ

ЭХБХ-ИЙН БХ-ИЙН АХЛАГЧ

Б.ЦЭНДСҮРЭН

ХХХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН

Н.ОДГЭРЭЛ

БОЛОВСРУУЛСАН:

ЦШС-НИЙ ЦЕХИЙН ДАРГА

Ж.БАЯР